

СУДАЛГААНЫ НЭР:

**ТАРХИНЫ ҮХЭЛТЭЙ ДОНОРЫН
ИЛРҮҮЛЭГ МОНГОЛ УЛСАД - 2020**

СУДЛААЧ:

П.БАТЧУЛУУН

ЭЭЭШСҮАЗА-ны ДАРГА

Б.АЛТАНТУЛГА

ЭЭЭШСҮАЗА-ны МЭРГЭЖИЛТЭН

Г.БАТЦЭЦЭГ

ЭЭЭШСҮАЗА-ны МЭРГЭЖИЛТЭН

Э.БАТЖАРГАЛ

ЭЭЭШСҮАЗА-ны МЭРГЭЖИЛТЭН

П.МИДРИЙМАА

ЭЭЭШСҮАЗА-ны МЭРГЭЖИЛТЭН

ТАРХИНЫ ҮХЭЛТЭЙ ДОНОРЫН ИЛРҮҮЛЭГ МОНГОЛ УЛСАД 2020

ЗОРИЛГО

Монгол Улсын Донорын тухай хууль анх 2000 онд анх батлагдаж 2012 болон 2018 онуудад шинэчлэгдсэн. 2018 оны шинэчилсэн найруулгаар Эрүүл Мэндийн Хөгжлийн Төвийн Эс, эд, эрхтнийг шилжүүлэн суулгах үйл ажиллагааг зохицуулах албыг 2018 оны 03 дугаар сарын 01-нд байгуулж 5 хүний бүрэлдэхүүнтэй ажиллаж байна.

Манай улсад эрхтэн шилжүүлэн суулгах 2 эмнэлэг байна. Үүнд: 1. УНТЭ (Бөөр, Элэг, Ясны чөмөг үүдэл эс, Шөрмөс шилжүүлэн суулгах баг), 2. ХСҮТ (Элэг шилжүүлэн суулгах баг) болон дөрвөн донор эмнэлэг (УГТЭ, ГССҮТ, УНТЭ, УХТЭ) ажиллаж байна. Түүнчлэн 5 үр шилжүүлэн суулгах (ЭХЭМҮТ, CLWH, Unimed, RMC, Өүжин мед) эмнэлгүүдтэй хамтран ажилладаг билээ. 2020 оны жилийн эцсийн байдлаар нийт 131 хүнд элэг шилжүүлэн суулгах мэс засал (УНТЭ-107, ХСҮТ-25), 227 хүнд бөөр (УНТЭ) шилжүүлэн суулгах мэс засал, 22 хүнд ясны чөмөгнөөс үүдэл эс шилжүүлэн суулгах эмчилгээг (УНТЭ) амжилттай хийгээд байна. Үүнээс 2018 онд 1 тархины үхэлтэй донороос 2 хүнд бөөр шилжүүлэн суулгах мэс засал, 2019 онд 8 тархины үхэлтэй донороос 11 хүнд бөөр, 8 хүнд элэг шилжүүлэн суулгах мэс засал, 2020 онд 5 тархины үхэлтэй донороос 6 хүнд бөөр шилжүүлэн суулгах мэс засал, 3 хүнд элэг шилжүүлэн суулгах мэс заслыг амжилттай зохион байгуулж нийт 30 хүнд амьдрал бэлэглээд байна.

Манай алба нь донор эмнэлгийн тархины үхэл тодорхойлох багтай өдөр бүр холбогдож мэдээлэл авах болон очиж ажлын байран дээр уулзахаас гадна тархины үхэлтэй боломжит донор гарсан тохиолдол бүрт гэр бүлийн гишүүдтэй уулзаж Эрүүл Мэндийн Сайдын 2019 оны А/164 дүгээр тушаалын “Амьгүй донорын гэр бүлийн гишүүний зөвшөөрлийн хуудас” танилцуулан донор болох санал тавьж гэр бүлийн гишүүдээс зөвшөөрөл авдаг. Шашин шүтлэг, сүсэг бишрэл, үзэл бодол, өөрсдөдөө байгаа дутуу ойлголт зэргээс шалтгаалж зарим тохиолдолд татгалздаг. Эдгээр гэр бүлийн зөвшөөрлийн хувийг ихэсгэсэнээр эрхтэн шилжүүлэн суулгах эмчилгээний тоо нэмэгдэж, олон хүний амь нас аврах боломж бүрдэнэ.

2020 оны 01 дүгээр сарын 01-ээс 12 дугаар сарын 21-ний өдрийн байдлаар

- Утсаар холбогдож мэдээлэл хүлээн авсан тоо – 990
- Эрчимт эмчилгээний тасгийн эмч нартай очиж уулзсан тоо – 120
- Тархины үхэлтэй боломжит донор илрүүлсэн тоо – 42
- Шалгуурт тэнцээгүй – 29
- Шалгуурт тэнцсэн – 13
- Тархины үхэлтэй донорын гэр бүлтэй уулзсан уулзалтын тоо -13
- Гэр бүлтэй уулзах явцад нас барсан - 3
- Тархины үхэлтэй донорын гэр бүл татгалзсан тоо - 4
- Тархины үхэлтэй донорын гэр бүл зөвшөөрсөн тоо – 6
- Донор болоогүй – 1*
- Бодит донор болсон тоо - 5

- Тархины үхэлтэй донорын эмнэлгүүдэд ажилласан цаг – 320

**Тархины үхэлтэй боломжит донорын гэр бүлтэй уулзалт зохион байгуулж, зөвшөөрөл авах явцад болон зөвшөөрөл авсны дараа тархины үхэлтэй боломжит донорын амин үзүүлэлт унаж, нас барсан. Энэ үед уг уулзалтыг бүрэн зогсоосон.*

Уулзалт хийсэн гэр бүлүүдтэй 2-3 удаа уулзаж сайтар учирлан тайлбарлаж, санал, хүсэлт тавьж байсан. Яриаг эмх цэгц, дэс дараалалтай, тухайн нөхцөл байдалд тохируулан аядуу зөөлөн, тайван хүндэтгэсэн байдалтай, асуултыг нь анхааралтай хүлээн авч товч тодорхой хариулт өгөх байдлаар хийж байсан.

ҮР ДҮН

Судалгаанд 4 донор эмнэлгийн тархины үхэл тодорхойлох багийн үзлэгээр тодорхойлогдсон тархины үхэлтэй донорын гэр бүлийн гишүүдтэй уулзсан байдалд дүн шинжилгээ хийсэн. Нийт тархины үхэлтэй 13 донорын гэр бүлийн гишүүдтэй уулзах уулзалтыг зохион байгуулсан бөгөөд 6 (46.1%) гэр бүл зөвшөөрч, 4 (30.7%) гэр бүл татгалзсан. 3 (23.2%) гэр бүлтэй уулзах явцад тархины үхэлтэй боломжит донор зүрх зогссон тул үйл ажиллагааг бүрэн зогсоосон. Зөвшөөрсөн 6 тархины үхэлтэй донороос 5-аас нь эрхтэн авах мэс засал хийн 6 бөөр, 3 элэг шилжүүлэн суулгах мэс заслыг амжилттай хийж 9 хүний амь нас аварсан.

Татгалзсан гэр бүлийн шалтгааныг авч үзвэл

- Шашины үзлээс шалтгаалсан - 2
- Гэр бүлийн гишүүдийн хоорондын үзэл бодлоос шалтгаалсан – 2
 - Эдгээр гэр бүлүүд санхүүгийн дэмжлэг байгаа эсэхийг асууж байсан
 - Мэс хүргэмээргүй байна гэдэг шалтгааныг гэр бүл бүр илэрхийлж байсан

Мөн эрхтэн шилжүүлэн суулгах эмчилгээ, донорын тухай ойлголтыг судалж үзэхэд эдгээр гэр бүлийн 5 (38.7%) нь тодорхой ойлголттой байсан нь 2 гэр бүл, сайтар учирлан тайлбарласны үр дүнд 3 гэр бүл донор болгохыг зөвшөөрсөн болно. Харин татгалзах хариу өгсөн 8 (61,3%) гэр бүлээс Донор болон эрхтэн шилжүүлэн суулгах эмчилгээний талаар ойлголттой хэдий ч 2 гэр бүлийн гишүүдийн хоорондын үзэл бодлоос шалтгаалан татгалзсан бөгөөд 6 тохиолдолд лам, бөөгөөс асууж өөрсдөө хэлэлцсэний эцэст татгалзсан хариу өгсөн ба Донорын талаар, эрхтэн шилжүүлэн суулгах эмчилгээний талаарх мэдээлэл, ойлголт тааруу байсан болно.

ДҮГНЭЛТ

2020 оны дээрх тоон үзүүлэлтээс харахад олон нийтийн ойлголт эрхтний донорын талаарх мэдээлэл тодорхой хэмжээгээр хийж байгаа боловч тэр бүр иргэдэд сайн хүрээгүй бөгөөд Донорын талаар ойлголт бага хомс байгаа нь ажиглагдсан. Иймд бид олон нийт, эмч эмнэлгийн мэргэжилтнүүдэд чиглэсэн сургалт ухуулга, сурталчилгааны ажлуудыг улам эрчимжүүлэх, үе шаттайгаар хийх, олон нийтийн байгууллагатай хамтрах байдлаар хүргэх нь чухал байна.